


Төрийн албаны зөвлөлийн
2024 оны 06 дугаар сарын 27-ний өдрийн
284 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралт



АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан үндэслэл:

- Төрийн албаны тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан шинэчлэн боловсруулсан
 Хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон

Холбогдох хууль тогтоомжийн нэр, огноо:

Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай
хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай
хууль (2023.01.06)

Дагаж мөрдөх огноо:

2023.03.01

Албан тушаалын тодорхойлолтыг
баталсан огноо:

24 06 27

Байгууллагын нэр:

Нэгжийн нэр:

Гадаадын иргэн, харьяатын газар

Хилийн боомт, орон нутаг дахь газар

Албан тушаалын нэр:

Албан тушаалын ангилал, зэрэглэл

Хяналтын улсын ахлах байцаагч

Дэс түшмэл, ТТ-7

Ажлын цаг:

Ажлын байрны албан ёсны байршил:

Ажлын өдрийн 8 цаг

Тухайн орон нутагт

Хөдөлмөрийн нөхцөл:

Онцгой нөхцөл:

Хэвийн

Албан ажлын онцгой нөхцөлд хамаарна.

II. АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ


Албан тушаалын зорилго:

Байгууллагын стратеги төлөвлөгөө, зорилт чиг үүргийн хүрээнд гадаадын иргэний талаарх болон бусад хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, хяналт шалгалтын үйл ажиллагааг зохион байгуулах, хяналтын улсын байцаагчдын үйл ажиллагаанд хяналт тавих, хариуцсан чиг үүргийн хүрээнд удирдлагыг мэргэжил арга зүй, бодит мэдээ, мэдээллээр хангах чиг үүргийг хэрэгжүүлж, гүйцэтгэлийн үр дүнг нэгжийн даргын өмнө хариуцна.

Албан тушаалын зорилт:

- 1.Хилийн боомтод холбогдох хууль тогтоомжийн дагуу гадаадын иргэдэд виз олгох, оршин суух зөвшөөрлийн бүртгэлээс хасалт хийх, хилээр зорчих гадаадын иргэнд хяналт тавих ажлыг зохион байгуулах;
- 2.Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль тогтоомжийн дагуу аймаг, орон нутгийнхаа хэмжээнд гадаадын иргэдийн зорчих хөдөлгөөнд хяналт тавих;
- 3.Зөрчил гаргасан хүн, хуулийн этгээдийн талаар мэдээллийн сан бүрдүүлж, зөрчил шийдвэрлэлтэд хяналт тавих, үндэсний аюулгүй байдлыг хангах чиг үүргийн хүрээнд баримт бичгийн хуурмаглалыг таних, судлах, холбогдох судалгаа мэдээллийн сан бүрдүүлэх, илэрсэн зөрчлийг шийдвэрлэх;
- 4.Хууль тогтоомжид заасан бусад чиг үүргийг хэрэгжүүлэх.

Зорилт	Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хариуцлага, оролцооны хэлбэр Туслах-Т Гүйцэтгэх-Г Хянах-Х Шийдвэрлэх -Ш
1 дүгээр зорилтын хүрээнд	1.Визийн зөвшөөрөл хүссэн иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хүсэлтийг хянах, санал дүгнэлт гаргах;	Хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо, үр дүн	Х, Ш
	2.Орон нутагт хувийн хэргээр оршин суух зөвшөөрөл хүссэн иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хүсэлтийг хянах, санал, дүгнэлт гаргах;	Хууль тогтоомжид нийцсэн байна.	Г, Х
	3.Хил орчмын нутаг дэвсгэрт зорчих үнэмлэхтэй болон тухайн орон нутагт оршин суугч гадаадын иргэний бүртгэлийг хөтөлж, хяналт тавих;	Хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо, үр дүн	Г, Х
	4.Орон нутагт үйл ажиллагаа явуулдаг гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж, байгууллагын мэдээллийг гаргаж, судалгааны нэгдсэн системд баяжилт хийх, хяналт тавих;	Хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо, үр дүн	Г, Х
	5.Монгол Улсад түр ирэгч, гадаадын иргэний визийн хугацааг сунгах, бүртгэсэн хүртэл тэмдэглэгээ хийх эсэхийг хянан шийдвэрлэх;	Хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо, үр дүн	Х, Ш
	6.Монгол Улсад орохыг үл зөвшөөрсөн, хориг арга хэмжээ авагдсан гадаадын иргэнийг хил дээрээс буцаах арга хэмжээ авах.	Хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо, үр дүн	Х, Ш
	1.Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль болон бусад хууль тогтоомжийг зөрчихөөс урьдчилан сэргийлэх, зөрчсөн үйлдлийг илрүүлэх, таслан зогсоох зорилгоор төлөвлөгөөт, төлөвлөгөөт бус хамтарсан хяналт	Хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо, үр дүн	Г, Х



2 дугаар зорилтын хүрээнд	шалгалтыг орон нутагт зохион байгуулж, дүнг байгууллагын удирдлагад танилцуулах, гарсан шийдвэрт хяналт тавих;		
	2.Хилийн боомт, орон нутагт зорчих гадаадын иргэн, баримт бичигт үзлэг шалгалт хийх, шаардлагатай гадаадын иргэнтэй ярилцлага хийх, тэмдэглэл хөтлөн баталгаа гаргуулах, зорчих эрхийг хязгаарлах ажлыг зохион байгуулах;	Хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо, үр дүн	Г, Х
	3.Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль тогтоомжийг зөрчсөн хүн, хуулийн этгээдийн зөрчлийг Зөрчлийн тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэх, шаардлагатай тохиолдолд шийтгэл ногдуулж, хэрэгжилтийг хангуулах;	Хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо, үр дүн	Г, Ш
	4.Орон нутгийн төмөр зам, авто зам болон агаарын тээврийн хэрэгслээр зорчигч гадаадын иргэдийн шилжилт хөдөлгөөнд хяналт тавих, баримт бичигт үзлэг шалгалт хийх, хил орчмын нутаг дэвсгэрт зорчих үнэмлэхтэй гадаадын иргэний хөдөлгөөн болон хилийн бүсэд эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүй хөдөлмөр эрхэлж буй эсэхэд хяналт тавих;	Хууль тогтоомжид нийцсэн байна.	Г, Х
	5.Монгол Улсаас албадан гаргасан, албадан гаргахаас чөлөөлсөн, албадан гаргасан шийдвэрийг цуцалсан, гарахыг түдгэлзүүлсэн гадаадын иргэний зорчих хөдөлгөөнд хяналт тавих;	Хууль тогтоомжид нийцсэн байна.	Х
	6.Хариуцсан чиг үүргийн дагуу холбогдох хууль тогтоомжийн төсөлд санал оруулах ажлыг зохион байгуулах, хяналт тавих.	Хууль тогтоомжид нийцсэн байна.	Г, Х
3 дугаар зорилтын хүрээнд	1.Хуульд заасан үндэслэлээр гадаадын иргэнийг саатуулах, бичиг баримтын бүрдүүлэлт, хариуцсан нутаг дэвсгэр дэх гадаадын иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын байршлын судалгаа, ашиглалтад хяналт тавих;	Хууль тогтоомжид нийцсэн байна.	Г, Х
	2.Хяналтын улсын байцаагчийн гадаадын иргэнийг албадан гаргах тухай дүгнэлтийн эрх зүйн үндэслэл, албадан гаргах ажиллагаа, зөрчил шалган шийдвэрлэлтэд хяналт тавих,	Хууль тогтоомжид нийцсэн байна.	Г, Х




	хяналтын улсын байцаагч, мэргэжилтний үйл ажиллагаанд мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх;		
	3.Зөрчил гаргасан хүн, хуулийн этгээдэд зөрчил шийдвэрлүүлэх талаар албан шаардлага, гарах сануулга өгөх, хэрэгжилтийг хангуулах;	Хууль тогтоомжид нийцсэн байна.	Г, Х
	4.Олон улсын болон гадаад улсын төрийн бус байгууллагын салбар, төлөөлөгчийн газар, Монгол Улсын харьяат хүүхдийг гадаадын иргэнд үрчлүүлэх, иргэний харьяаллын асуудлаар зөвлөгөө, мэдээлэл өгөх, хоёрдмол харьяалал үүсгэсэн гадаадын иргэний асуудлыг илрүүлж, төв байгууллагын холбогдох албан тушаалтанд танилцуулах;	Хууль тогтоомжид нийцсэн байна.	Г
	5.Байгууллагын үндсэн үйл ажиллагаатай холбоотой хууль тогтоомжийн талаар албан хаагчдад сургалт, мэдээлэл зохион байгуулж, хилийн боомт, орон нутаг дахь газар, хэлтсийн үйл ажиллагаанд ашиглаж буй тэмдэг, дардасны бүртгэлийг хөтөлж, хяналт тавих;	Хууль тогтоомжид нийцсэн байна.	Г
	6.Үндэсний аюулгүй байдлыг хангах чиг үүргийн хүрээнд баримт бичгийн хуурмаглалыг таних, судлах, холбогдох судалгаа мэдээллийн сан бүрдүүлэх, илэрсэн зөрчлийг шийдвэрлэх.	Хууль тогтоомжид нийцсэн байна.	Г
4 дүгээр зорилтын хүрээнд	1.Монгол Улсын Үндсэн хууль, Төрийн албаны тухай, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай, Хөдөлмөрийн тухай, Захиргааны ерөнхий, Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай, Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай, Харьяатын тухай, Монгол Улсын хилийн тухай хууль, Төрийн хяналт шалгалтын тухай, Зөрчлийн тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай, Төрийн болон албаны нууцын тухай, Архивын тухай, Нийтийн албанд, нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, байгууллагын “Хөдөлмөрийн дотоод журам” болон бусад хуульд тогтоомжид заасан чиг үүргийг хэрэгжүүлэх;	Хууль тогтоомжид нийцсэн байна.	Г
	2.Эрхэлсэн ажлын чиг үүргийн хэрэгжилтийг бүрэн хариуцаж, зөрчил	Хууль тогтоомжид нийцсэн байна.	Г



	дутагдал гарсан тохиолдолд хариуцлага хүлээх;		
	3.Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль тогтоомжийг сахиж, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хууль тогтоомж, стандартыг биелүүлэх;	Хууль тогтоомжид нийцсэн байна.	Г
	4.Хөрөнгө орлогын мэдүүлгээ хуульд заасан хугацаанд үнэн зөв тайлагнах;	Хууль тогтоомжид нийцсэн байна.	Г
	5.Архив, албан хэрэгт хөтлөлтийн стандартад нийцсэн баримт бичгийн төсөл боловсруулах, иргэн аж ахуйн нэгж, байгууллагаас ирүүлсэн өргөдөл, гомдол мэдээллийг хугацаанд нь шийдвэрлэх;	Хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо, үр дүн	Г
	6.Иргэн, аж ахуйн, нэгж байгууллагыг хариуцсан ажлын чиглэлээр үнэн зөв бодитой мэдээллээр хангах, арга зүйн зөвлөгөө өгөх;	Хууль тогтоомжид нийцсэн байна.	Г
	7.Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж, батлуулах, хэрэгжилтийг хангах, тайлагнах;	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь, үнэлгээ	Г
	8.Байгууллагаас зохион байгуулж буй олон нийтийн арга хэмжээнд идэвхтэй оролцох;	Оролцсон арга хэмжээний тоо	Г
	9.Удирдлагаас өгсөн хууль ёсны үүрэг даалгаврыг биелүүлэх.	Гүйцэтгэлийн хувь	Г

III.АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА

Боловсрол	Бакалавр ба түүнээс дээш боловсролын зэрэгтэй.	
Мэргэжил	-эрх зүй (0421); -менежмент ба удирдахуй (0413); -аюулгүй байдлыг хангахад ангилагдаагүй чиглэл (1039).	
Мэргэшил	-	
Туршлага	Туслах түшмэлийн албан тушаалд ажилласан бол давуу тал болно.	
Ур чадвар	Дүн шинжилгээ хийх	<ul style="list-style-type: none"> - баримт бичигт дүн шинжилгээ хийх, үнэлэлт, дүгнэлт өгөх чадвартай байх; - судалгааны арга зүйн мэдлэгтэй байх; - мэдээлэл дэх дутуу, алдаатай нийцтэй бус байдлыг илрүүлэх; - гүйцэтгэж буй ажлын явц, үр дүнг тайлагнах; - албан тушаалын чиг үүргээ хэрэгжүүлэхэд учирч болзошгүй эрсдэлийг урьдчилан тооцох, бууруулах арга хэмжээ авч хэрэгжүүлэх;



		<ul style="list-style-type: none"> - нэгжийн дотоод хяналтыг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд оролцох, үр дүнг тайлагнах; - бусад.
	Асуудал шийдвэрлэх	<ul style="list-style-type: none"> - Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуулийг чандлан баримталж, үндэсний язгуур ашиг сонирхолд захирагдан ард түмэндээ үйлчлэх; - албан тушаалын бүрэн эрхийн хүрээнд хуульд нийцсэн, оновчтой шийдвэрийг шуурхай гаргах; - асуудлыг хууль тогтоомж, ёс зүйн зарчимд нийцүүлэн ашиг сонирхлоос ангид шийдвэрлэх; - гаргасан шийдвэрийнхээ талаар хариуцлага хүлээх; - бусад.
	Багаар ажиллах	<ul style="list-style-type: none"> - өөрийн мэдлэг чадвар, өөрт байгаа мэдээллийг баг хамт олонтой хуваалцаж хамтран ажиллах, үлгэрлэн манлайлах; - бусадтай харилцан итгэл төрүүлэхүйц ажил хэрэгч харилцаа бий болгох; - ажил хэрэгч, бүтээлч, санаачилгатай ажиллах; - хувийн зохион байгуулалт, ажлын цаг ашиглалтын хувьд бусдыг манлайлах; - бусад.
	Бусад	<ul style="list-style-type: none"> - албан хэрэг хөтлөх, бодлогын баримт бичиг боловсруулах; - англи хэл, эсхүл бусад гадаад хэлээр албан тушаалын чиг үүрэгт хамаарах мэдээллийг ашиглах; - компьютерын хэрэглээний программ, мэдээллийн технологийн дэвшилтэт аргыг ашиглах; - бусдад хүндэтгэлтэй, соёлтой, адил тэгш хандах.

IV.АЛБАН ТУШААЛТНЫ ХАРИЛЦАХ СУБЪЕКТ

Албан тушаалыг шүүд харьяалан удирдах албан тушаалын нэр:
Хилийн боомт, орон нутаг дахь газрын дарга

Албан тушаалд шүүд харьяалан удирдуулах албан тушаалын нэр, тоо:

Бусад харилцах субъект:

- Гадаад орон, олон улсын байгууллага төрийн болон тусгайлсан чиг үүргийн байгууллага, төрийн бус байгууллага;
- Иргэн, хуулийн этгээд, мэргэжлийн байгууллага.

V.АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ

Албан тушаалын тодорхойлолт боловсруулсан:

Албан тушаалын тодорхойлолтыг хянаж, батлах зөвшөөрөл олгосон байгууллагын шийдвэр:


Албан тушаал
ЗАХИРГАА УДИРДЛАГЫН ГАЗРЫН ДАРГА
.....И.БААТАРХҮҮ

Байгууллагын нэр:
ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ

Шийдвэрийн огноо:


Дугаар: 284

1110 2024 оны 06 сарын 27-ны өдөр



Албан тушаалын тодорхойлолтыг баталсан:

Байгууллагын нэр:
ГАДААДЫН ИРГЭН ХАРЬЯТЫН ГАЗАР
Шийдвэрийн огноо: 2024.06.27
Дугаар: А/27
(тамга/тэмдэг)



A handwritten signature in black ink, appearing to be 'N. UUGANBAYAR'.

ДАРГА..... Н.УУГАНБАЯР
(Гарын үсэг) (Эцэг/эх/-ийн нэр, өөрийн нэр)

2024 оны 06 дугаар сарын 27-ны өдөр

